



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/154

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арга хэмжээний хүрээнд хийгдэх “Үндэсний сур харвааны нум сум сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)


Гишүүн: Г.Гантулга
(Сурын холбооны гишүүн)

Нарийн бичгийн дарга: Б.Алтансүх
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Сумын хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арга хэмжээний хүрээнд хийгдэх “Үндэсний сур харвааны нум сум сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах ажил”-ын шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу хүлээн авч, тайлагнахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА